



### ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 44

Есөнбулаг сум

#### Төмс хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэн аймгийн хүн амыг эрүүл чанартай төмсөөр бүрэн хангах зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор “Төмс” хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөв, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган батлуулж, биелэлтийн явцыг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
20.17 оны 15 дугаар сарын 29-ны  
өдрийн 77 дүгээр тогтоолын  
1-р хавсралт



247

## ТӨМС ХӨТӨЛБӨР

### **Нэг. Төмс үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, хөтөлбөр боловсруулах үндэслэл:**

Манай аймгийн газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн дотроос хүнсний хангамжийн тодорхой хэсгийг төмс эзэлж байдаг. 2016 оны байдлаар аймаг нийт 84 га-д төмс тариалж 705 тонн төмс хурааж авсан нь дотоодын хэрэгцээний 25 хувийг хангаж байгаа юм. Үлдсэн 75%-ийн төмсний хэрэгцээг хөрш зэргэлдээ Ховд аймаг болон Улаанбаатар хотоос авч хангаж байгаа нь хүнсний аюулгүй байдлыг хангаж, төмсний аймгийн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байгаа юм. Ховд аймгаас нийлүүлж байгаа төмс чанар муу, хятадын үр сорттой холилдсон, ургамал хамгааллын болон түргэн ургуулах бодис ихээр хэрэглэдэг учир хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх магадлалтай байгаа.

Цаашдаа аймгийн 1 жилийн төмсний хэрэгцээг хангахад 55468 жишмэл хүн амд 2880 тн төмс шаардлагатай бөгөөд энэ нь 336 га-д 840 тн үрийн төмс тариалж 1 га-гаас 80.5 цн ургац авч байж 100%-д хүрнэ.

Төмс нь бусад хүнсний ногооноос хамгийн их өргөн хэрэглэгддэг төрөл юм. Төмсийг орон нутагтаа тариалж, аймгийн хэрэгцээг 100% хангаснаар 120 ажлын байр шинээр бий болж, ажилгүйдэл буурч, үүнийг дагасан жижиг, дунд үйлдвэрүүд хөгжих боломжтой.

Тиймээс Говь-Алтай аймгийн хөрсөнд ургасан эрүүл, зах зээлийн боломжит үнэд тохирсон төмсний хэрэгцээ байгаа юмаа.

Хүнсний зориулалт бүхий төмс нь хүний биед онцгой ач холбогдолтой. Цусны даралт бууруулах, ходоодны шарх үрэвсэл, гэдэсний түгжрээ, түлэгдлийн шарх болон арьсны намарс буюу экземийг эмчлэхэд уламжлалт ардын эмнэлэгт өргөн хэрэглэж ирсэн.

Төмс нь бөөрөнхий байцаа, шар луувангаас хоёроос гурав дахин илүү илчлэг чанартай юм. Нэг тонн төмснөөс 170 кг цардуул 160 кг дектрин буюу шингэн глюкоз 12 литр спирт, эсвэл 55 кг цэвэр нүүрсний хүчил зэргийг гарган авдаг байна.

100 грамм төмсөнд 0.2 грамм тос, 17 г нүүрс ус, 2 г уураг агуулагдаж байдаг. Мөн цайр, магни, фосфор, мангани, төмөр зэрэг эрдэс бодистой зэрэг онцлог шинж чанартай учраас хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой.

Дээрх хэрэгцээ, шаардлагыг үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

#### **Хоёр. Хөтөлбөрийн зорилго:**

Говь-Алтай аймгийн төмсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, төмсний хэрэгцээг 100% ханган борлуулалтын сүлжээг бий болгоход оршино.

#### **Гурав. Хөтөлбөрийн зорилт**

3.1. Энгийн болон инженерийн хийцтэй услалтын 2-3 системийг түшиглэн төмсийг дагнан тариалж, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэн аймгийн дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, зоорийн тоог нэмэгдүүлэх

3.2. Аймгийн төмсний тариалалтын бүс нутаг, цаг уурын онцлогт тохирсон төмсний нутагшсан сортын үртэй болох

3.3 Төмсийг боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулах, борлуулалтын сүлжээ бий болгох

3.4 Ажиллах боловсон хүчний чадавхийг бэхжүүлж, нөөцийг нэмэгдүүлэх замаар шинээр ажлын байр бий болгох

3.5 Сум, орон нутаг, аж ахуйн нэгж, айл өрх бүр төмс тариалж дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

#### **Дөрөв. Зорилтууддаа хэрэгжүүлэх арга хэмжээ**

##### **4.1. Нэгдүгээр зорилтын хүрээнд**

4.1.1 Услалтын систем бүхий газруудад төмс тариалалтыг нэмэгдүүлэх

Үүний тулд:

- Чандманы Хөрхрөө, Халиуны Ёлтон, Шаргын урд гол, Даривын Харгана түрүү зэрэг услалтын системүүдэд төмсний тариалалтын 70%-ийг тариална.

- Бусад услалтын систем болон булаг шандыг ашиглан 30%-ийг тариална. Усалгааны эх үүсвэртэй газруудад төмс тариалалтыг нэмэгдүүлнэ.

4.1.2 Тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд хөрс боловсруулах, төмс тарих, арчлах хураах, техникийн хангамжийг нэмэгдүүлнэ.

4.1.3 Төмсний га-ийн дундаж ургацыг нэмэгдүүлэхийн тулд хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтолыг бууруулах, таримлын зохистой сэлгээг хийж хэвшүүлнэ.

4.1.4 Тариаланчдыг хөрөнгө оруулалт, урт хугацаатай санхүүгийн зээл /сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, ОНХС гэх мэт/- ийн бодлогоор дэмжиж ажиллана.

4.1.5 Усыг ариг гамтай зарцуулах технологи нэвтрүүлэх, усалгааны техникээр хангах, дуслын услалтын систем, бороожуулагчийг нэвтрүүлэх ажлыг 40%-д хүргэнэ.

4.1.6 Зоорийн хүчин чадлыг 500 тонноос доошгүйгээр нэмэгдүүлнэ.

**4.2. Хоёрдугаар зорилтын хүрээнд:**

4.2.1 Төмс тариалах газруудын нийт тариалсан талбайн 10-20 хувийг үрийн талбайтай болгоно.

4.2.2 Төмсний үрийн талбайд хог ургамал, өвчин хортноос хамгаалах ургамал хамгаалалын иж бүрэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.2.3. Жил бүр сортын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлнэ.

4.2.4 Үр хадгалах, агуулах зоорийн хэмжээг 500-аас доошгүй тонноор нэмэгдүүлнэ.

4.2.5 Орон нутагт дасан зохицон ургах төмсний сортыг нутагшуулна.

**4.3 Гуравдугаар зорилтын хүрээнд:**

4.3.1 Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын төмсний хэрэгцээг хангана.

4.3.2 Төмсөнд анхан шатны боловсруулалт хийх жижиг оврын үйлдвэр байгуулан хүн амын төмсний хэрэглээг нэмэгдүүлнэ.

4.3.3 Орон нутагт тариалсан төмсний борлуултыг дэмжиж, үзэсгэлэн худалдаа, туршлага судлах ажлыг зохион байгуулна.

**4.4 Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:**

4.4.1 Төмс тариалагчдын чадавхийг бэхжүүлэх мэргэжлийн болон аж ахуй эрхлэлтийн сургалтыг тогтмол зохион байгуулна.

4.4.2 Талбайн үзүүлэх сургалтыг 2 жил тутам хийнэ.

4.4.3 Ажилгүй иргэдийг гэр бүлээр нь ажиллуулах замаар ажлын байр бий болгох, өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг сумдууд амьжиргааг дэмжих зөвлөлтэй хамтран шийдвэрлэнэ.

4.4.4 Мэргэжлийн сургуулиудтай хамтран агрономич бэлтгэн сумдын МЭҮТ болон аж ахуй нэгжээс ажлын байраар хангана.

**4.5 Тавдугаар зорилтын хүрээнд**

4.5.1 Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 30%-ийг газар тариалан тэр дундаа төмс тариалахад шаардагдах зардалд зарцуулна.

4.5.2 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн 20-иос доошгүй хувиар төмс тариалах хүсэлтэй болон үйлдвэрлэлээ өргөжүүлэх иргэн, аж ахуй нэгжийг дэмжинэ.

4.5.3 Сум орон нутаг, аж ахуйн нэгж, айл өрх бүр төмс тариалах ажлыг өрнүүлж, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн төмсний хэрэгцээг хангалтыг жил бүр өсгөх ажлыг зохион байгуулна.

#### **Тав. Хөтөлбөрийн санхүүжилт**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана.

5.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалт;

5.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;

5.3 Дотоод, гадаадын иргэн, хуулийн этгээдийн өөрийн хөрөнгө;

5.4 Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх сан, банкны зээл;

5.5 Тариалан эрхлэлтийг дэмжих сан

5.6 Гадаад улс, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр, буцалтгүй

тусламж, хөнгөлөлттэй зээл.

#### **Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт**

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, зохицуулах чиг үүргийг аймгийн ЗДТГ, ХХААГ хэрэгжүүлнэ. Сумдад сумын ЗДТГ хариуцан хэрэгжүүлнэ.

6.2 Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөв, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнөөс тусгаж хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллана.

6.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчаас сумын Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тусгуулан хамтарч ажиллана.

#### **Долоо. Төслийн хэрэгжилтийг тайлагнах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх**

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, гүйцэтгэсэн ажлын тайланг жил бүрийн 4 дүгээр улиралд гарган аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст өгч үнэлгээ хийлгүүлнэ.

7.2 Хөтөлбөрт хийсэн үнэлгээний дүнг аймгийн засаг даргын зөвлөл болон аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэрүүлэгчдэд танилцуулж байна

#### **Найм. Хөтөлбөр хэрэгжих хугацаа:**

8.1 Хөтөлбөрийг 2017-2020 оны хооронд хэрэгжүүлнэ.

#### **Ес. Хүрэх үр дүн**

9.1 2020 он гэхэд төмсний үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна.



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
 2017 оны 05 дугаар сарын 22-ны  
 өдрийн 44 дүгээр тогтоолын  
 02-р хавсралт

ТӨМС ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 2017-2020

№	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хөрөнгө, эх үүсвэр	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
1	Энгийн болон инженерийн хийцтэй услалтын 2-3 системийг түшиглэн төмсийг дагнан тариалж, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэн аймгийн дотоодын хэрэгцээ бүрэн хангаж, зоорийн тоог нэмэгдүүлэх	80-100 морины хүчин чадал бүхий 2ш тракторын иж бүрдлээр Шарга сумын Урд гол, Чандмань сумын Хөрхрөөгийн услалтын системд нийлүүлж, тариалалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	2018 он	200 сая, улсын төсөв	АЗДТГ, ХХААГ	Дарив, Чандмань сумын Засаг даргын тамгын газар
2		Дарив сумын Харгана түрүүгийн услалтын системд хөрөнгө оруулалт хийж 30-50 га-д төмс тариална.	2018 он	150 сая гадаадын хөрөнгө оруулалт, улсын төсөв	АЗДТГ, ХХААГ	Дарив сумын ЗДТГ
3		Дарив, Чандмань суманд 100 тн-оос доошгүй багтаамжтай зоорийг барина.	2018-2019	100 сая, хувийн хөрөнгө оруулалт	АЗДТГ, ХХААГ	Дарив, Чандмань сумын ЗДТГ
4		Халиун сумд шинээр 300 тонноос доошгүй 1 ширхэг зоорийг шинээр бариж ашиглалтанд оруулна.	2017-2018	150 сая, хувийн хөрөнгө оруулалт	"Ханлиг тайшир" ХХК	АЗДТГ, ХХААГ
5		Төмсний тариалалтын нийт талбайд бороожуулагч, дуслын усалгааны системийг 40%-д нэвтрүүлнэ.	2018-2020	150 сая, улсын төсөв	АЗДТГ, ХХААГ	Хувийн хэвшлүүд
6		Халиун сумын Ёлтонгийн услалтын системд гадаадын хөрөнгө оруулалтыг	2017-2018	900 сая, гадаадын	"Ханлиг тайшир" ХХК	АЗДТГ, ХХААГ Халиун сумын ЗДТГ

		татаж 100 га-д төмс тариална.		хөрөнгө оруулалт		
7	Аймгийн төмсний тариалалтын бүс нутаг, цаг уурын онцлогт тохирсон	Гала, Санте, Куарта, Витара, Солист зэрэг сортыг тариалан хамгийн өндөр ургац өгдөг өвчин хортонд тэсвэртэй амт чанар сайтай сортыг сонгон нутагшуулна.	2018-2020	-----	АЗДТГ, ХХААГ	ТЭДС
8	төмсний нутагшсан сортын үртэй болох	Тариалан эрхлэгчдэд үрийн төмсийг 30%-ийн хөнгөлөлтөөр олгож, тариаланчдыг дэмжинэ.	2018-2019	150 сая, АОНХС	АЗДТГ, ХХААГ	
9		Үрийн аж ахуйг хөгжүүлнэ.	2018-2020	150 сая, АОНХС	Хувийн хэвшил	АЗДТГ, ХХААГ
10	Төмсийг боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулах, борлуулалтын сүлжээ бий болгох	Аймгийн бүх сургууль, цэцэрлэг, эмнэлэгүүдийн төмсний хэрэгцээг 100% дотоодын үйлдвэрлэлээр хангана.	2017-2020	-----	АЗДТГ, ХХААГ	ЭМГ, БСУГ, Бүх сургууль, цэцэрлэг, эмнэлэг
11		Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон хувийн хэвшлүүдийг төмсөөр 100% хангана.	2017-2020	-----	АЗДТГ, ХХААГ	Тухайн сумын ЗДТГ
12		Чипсний үйлдвэр байгуулна.	2018	140 сая, хувийн хөрөнгө оруулалт	Хувийн хэвшил	ХХААГ
13	Ажиллах боловсон хүчний чадавхийг бэхжүүлж, нөөцийг нэмэгдүүлэх замаар шинээр ажлын байр бий болгох	Мэргэжлийн сургуулиудтай хамтран боловсон хүчнийг бэлтгэн сумдын МЭҮТ-ийг агрономич мэргэжилтэй боловсон хүчнээр хангана.	2017-2020	-----	АЗДТГ, ХХААГ	Сумдын ЗДТГ
14		Тариалан эрхлэгчдийг төмс тариалах, арчлах, хураах, хадгалах агротехникийн сургалтанд жилд нэг удаа хамруулах ажлыг зохион байгуулна.	2017-2020	15 сая, төсөл хөтөлбөрөөс	АЗДТГ, ХХААГ	"Монгол ногоо" хөтөлбөр
15		Жил бүр 15-30 иргэнийг ажлын байраар ханган нийт 60-120 иргэнийг ажлын байраар ханган ажиллана.	2017-2020	----	АЗДТГ, ХХААГ	СЗДТГ, аж ахуйн нэгж

16		2 жилд 1 удаа үзүүлэх сургалтыг зохион байгуулан онол практикийн дадлагатай болгоно.	2018,2020	6 сая, ОНТ	АЗДТГ, ХХААГ	Сумдын ЗДТГ
17	Сум, орон нутаг, аж ахуйн нэгж, айл өрх бүр төмс тариалж дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 30%-ийг газар тариалан тэр дундаа төмс тариалахад шаардагдах зардалд зарцуулна.	2018, 2019	150 сая, ОНХС	АЗДТГ, Сумдын ЗДТГ	ХХААГ
18		Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн 20-иос доошгүй хувиар төмс тариалах хүсэлтэй болон үйлдвэрлэлээ өргөжүүлэх иргэн, аж ахуй нэгжийг дэмжинэ.	2018, 2019	100 сая СХС	АЗДТГ, Сумдын ЗДТГ	ХХААГ
19		Сум орон нутаг, аж ахуйн нэгж, айл өрх бүр төмс тариалах ажлыг өрнүүлж, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн төмсний хэрэгцээг хангалтыг жил бүр өсгөх ажлыг зохион байгуулна.	2017-2020	-----	АЗДТГ, Сумдын ЗДТГ	ХХААГ

ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСВИЙН ЗАДАРГАА /төсөл/  
сая төгрөгөөр

2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нийт төсөв	2411.0	2017	2018	2019	2020
Улсын төсөв	500.0		400.0	50.0	50.0
АОНХСан	300.0		150.0	150.0	
СОХСан	150.0	-	75.0	75.0	-
Гадаадын хөрөнгө оруулалт	900.0	900.0			
Хувийн хөрөнгө оруулалт	390.0		290.0	100.0	
Сум хөгжүүлэх сан	150.0		70.0	80.0	
Төсөл, хөтөлбөр	15.0		5.0	5.0	5.0
Орон нутгийн төсөв	6.0		2.5	2.5	1.0

153